



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/175/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

Цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын талаар 2022 онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан	15
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Залруулсан алдаа	16
5.2 Төлбөрийн акт	16
5.3 Зөвлөмж	17
6. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.20 № 02/59
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Н.МӨНХЗУЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бараа материалын үлдэгдэл зөрүүтэй, эмийн болон шатахууны зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй анхан шатны баримтын бүрдүүлэлт, эд хариуцагчийн тайлан гаргалт хангалтгүй, төсвийг зохистой үр ашигтай зарцуулаагүй, төрийн сангийн төлбөр тооцооны журам мөрдөөгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв нь тусгай зориулалтын шилжүүлгээс буюу улсын төсвөөс санхүүждэг байсан 2022 онд иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тарифаар тооцон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгодог болсон нь нэг иргэнээр тооцсон санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэрээр санхүүжих зарчимд шилжсэн байна.

Аудитын гол асуудал

021020155

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 91.4 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төв нь сумын 680 гаруй өрхийн 2419 гаруй иргэнд давхардсан тоогоор 3461 амбулаторийн үзлэгт хамруулж 233 иргэнийг хэвтүүлэн эмчилж 1639 ор хоног, дундаж ор хоног 7, орны фонд ашиглалт 46 хувьтай, 235 алсын дуудлагад үйлчилж, 50 гаруй эх төрүүлсэн статистик үзүүлэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,868,850.30</u>	<u>46,610,409.09</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,794,912.23	8,816,710
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,794,912.23	8,816,710
3121	Төгрөг	1,794,912.23	8,816,710
31211	Төрийн сангийн харилцах	1,794,912.23	8,816,710
33	АВЛАГА	28,040,145.37	6,039,364.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	898,645.37	898,645.37
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	27,141,500	-
335	Бусад авлага	-	5,140,718.87
3351	Байгууллагаас авах авлага	-	4,457,059.46
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	683,659.41
35	БАРАА МАТЕРИАЛ	24,033,792.70	31,754,334.85
351	Түүхий эд материал	9,492,999.85	14,652,801.90
35130	Эм боох материал	9,492,999.85	14,652,801.90
354	Хангамжийн материал	14,223,792.85	16,458,532.95
35420	Аж ахуйн материал	10,931,629.95	11,031,979.95
35460	Хүнсний материал	961,162.90	5,116,553
35470	Бусад хангамжийн материал	2,331,000	310,000
35600	Мал амьтад	317,000	643,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>370,395,795.89</u>	<u>387,210,967.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	370,395,795.89	387,210,967.82
392	Биет хөрөнгө	355,190,795.93	372,130,967.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,918,909	298,918,909
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,833,989.03)	(45,465,847.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	79,768,656	85,701,988
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,726,785.90)	(40,068,761.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,149,285.36	137,721,672.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,626,171.75)	(77,333,694.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,234,445.37	46,303,763.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,693,553.12)	(33,647,061.72)
393	Биет бус хөрөнгө	15,204,999.96	15,079,999.92
39301	Программ хангамж	1,250,000	1,250,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(125,000.04)	(250,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,080,000	14,080,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>424,264,646.19</u>	<u>433,821,376.91</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>18,749,013.00</u>	<u>63,590.27</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,749,013	63,590.27
413	Өглөг	18,749,013	63,590.27
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	63,590.27
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	18,749,013	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>405,515,633.19</u>	<u>433,757,786.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	405,515,633.19	433,757,786.64

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	201,605,647.02	201,605,647.02
51101	Өмч: - төрийн	201,605,647.02	201,605,647.02
512	Хуримтлагдсан үр дүн	103,495,093.93	131,906,247.38
51210	Өмнөх үеийн үр дүн	103,495,093.93	101,732,057.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	30,174,189.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,414,892.24	100,245,892.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>424,264,646.19</u>	<u>433,821,376.91</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	550,360,486.76	556,057,346.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	439,209,700.76	53,728,863.80
120	Нийтлэг татварын бус орлого	66,372,300.76	53,728,863.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,372,300.76	53,728,863.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	370,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	66,372,300.76	53,358,863.80
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	372,837,400	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	372,837,400	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	111,150,786	502,328,483
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,543,526	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,403,526	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,140,000	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	31,525,283
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	31,525,283
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,607,260	470,803,200
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,607,260	470,803,200
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	527,149,997.77	524,884,198.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,149,997.77	524,884,198.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,949,997.77	524,884,198.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,130,987.77	302,960,337
210101	Үндсэн цалин	194,284,521.40	199,766,491
210102	Нэмэгдэл	85,172,450	87,402,447
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,248,109.37	2,782,000
210104	Урамшуулал	21,425,907	13,009,399.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,101,300	37,078,370.31
210201	Тэтгэврийн даатгал	27,515,800	25,122,991.30
210202	Тэтгэмжийн даатгал	2,896,200	3,071,895.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,317,200	2,457,516.69
210204	Ажилгүйдлийн даатгал	579,300	578,815.13
210205	Эрүүл мэндийн даатгал	5,792,800	5,847,151.32

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,069,700	26,577,511.06
210301	Гэрэл, цахилгаан	1,643,900	1,834,196.90
210302	Түлш, халаалт	19,730,800	24,589,924.16
210303	Цэвэр, бохир ус	695,000	153,390
2104	Хангамж, бараа материалын зардал	25,705,550	28,681,805
210401	Бичиг хэрэг	1,000,000	5,453,615
210402	Тээвэр, шатахуун	20,205,550	19,550,700
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000	2,312,740
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	818,950
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		518,800
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	27,000
2105	Нормативт зардал	70,913,220.80	77,487,991.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,161,680.20	67,060,394
210502	Хоол, хүнс	8,591,240.60	9,233,597.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,160,300	1,194,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,958,100	7,973,666.65
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000	1,386,000
210602	Тавилга	958,100	41,666.65
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,596,000
210604	Урсгал засвар	-	950,000
2107	Томилолт, зочны зардал	700,000	1,435,300
210702	Дотоод албан томилолт	700,000	1,435,300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,437,500	405,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	300,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000	80,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000	25,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	832,500	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,933,639.20	42,284,216.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,113,736.48	13,395,945
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,819,902.72	28,888,271.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,200,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,200,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,200,000	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,210,488.99	31,173,148.01
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	998,958.55
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	998,958.55
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(998,958.55)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	23,210,488.99	30,174,189.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>479,604,656</u>	<u>529,839,983</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	372,837,400	370,000
120	Нийтлэг татварын бус орлого	-	370,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	370,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	370,000
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	372,837,400	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	372,837,400	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,767,256	529,469,983
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,132,196	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,132,196	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,027,800	31,525,283
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,027,800	31,525,283
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,607,260	497,944,700
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,607,260	497,944,700
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>477,809,743.77</u>	<u>522,818,185.23</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	477,809,743.77	522,818,185.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,609,743.77	522,818,185.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,130,987.77	299,011,602.81
210101	Үндсэн цалин	194,284,521.40	184,000,516.94
210102	Нэмэгдэл	85,172,450	88,427,868.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,248,109.37	5,887,000.00
210104	Урамшуулал	21,425,907	20,696,217.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,101,300	38,588,300
210201	Тэтгэврийн даатгал	27,515,800	26,684,300
210202	Тэтгэмжийн даатгал	2,896,200	2,971,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,317,200	2,385,200
210204	Ажилгүйдлийн даатгал	579,300	595,300
210205	Эрүүл мэндийн даатгал	5,792,800	5,951,800
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,069,700	28,387,090
210301	Гэрэл, цахилгаан	1,643,900	1,643,900
210302	Түлш, халаалт	19,730,800	26,489,800
210303	Цэвэр, бохир ус	695,000	253,390
2104	Хангамж, бараа материалын зардал	25,705,550.00	31,543,882.52
210401	Бичиг хэрэг	1,000,000	5,547,915
210402	Тээвэр, шатахуун	20,205,550	21,205,477.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000	2,192,840
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	1,438,550
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,159,100
2105	Нормативт зардал	48,506,606	97,752,424.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,846,306	81,354,076.90
210502	Хоол, хүнс	6,500,000	15,108,248
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,160,300	1,290,100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,958,100	9,360,000

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000	4,096,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,305,900
210604	Урсгал засвар	958,100	958,100
2107	Томилолт, зочны зардал	700,000	1,435,300
210702	Дотоод албан томилолт	700,000	1,435,300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,437,500	5,685,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,280,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	300,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000	80,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000	25,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	832,500	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000	11,054,585
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000	11,054,585
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,200,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,200,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,200,000	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,794,912.23</u>	<u>7,021,797.77</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,794,912.23	7,021,797.77
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,794,912.23
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,794,912.23	8,816,710

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	103,495,093.93	405,515,633.19
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	103,495,093.93	405,515,633.19
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	103,495,093.93	405,515,633.19
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	103,495,093.93	405,515,633.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,763,036.01)	(1,763,036.01)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	101,732,057.92	403,752,597.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(169,000)	-	(169,000)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	30,174,189.46	30,174,189.46
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,245,892.24	131,906,247.38	433,757,786.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	509,564,200	509,529,255.23	34,944.77	99.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,564,200	509,529,255.23	34,944.77	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	509,564,200	509,529,255.23	34,944.77	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,088,700	299,011,602.81	(42,922,902.81)	116.76
210101	Үндсэн цалин	154,071,500	184,000,516.94	(29,929,016.94)	119.43
210102	Нэмэгдэл	64,009,000	88,427,868.65	(24,418,868.65)	138.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,901,000	5,887,000	14,000	99.76
210104	Урамшуулал	32,107,200	20,696,217.22	11,410,982.78	64.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,736,400	38,588,300	(5,851,900)	117.88
210201	Тэтгэврийн даатгал	22,691,300	26,684,300	(3,993,000)	117.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,498,200	2,971,700	(473,500)	118.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,022,100	2,385,200	(363,100)	117.96
210204	Ажилгүйдлийн даатгал	502,300	595,300	(93,000)	118.51
210205	Эрүүл мэндийн даатгал	5,022,500	5,951,800	(929,300)	118.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,953,000	28,387,090	565,910	98.05
210301	Гэрэл, цахилгаан	1,643,900	1,643,900	-	100
210302	Түлш, халаалт	26,489,800	26,489,800	-	100
210303	Цэвэр, бохир ус	819,300	253,390	565,910	30.93
2104	Хангамж, бараа материалын зардал	40,273,100	31,543,882.52	8,729,217.48	78.32
210401	Бичиг хэрэг	5,892,900	5,547,915.00	344,985	94.15
210402	Тээвэр, шатахуун	24,005,200	21,205,477.52	2,799,722.48	88.34
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,833,500	2,192,840	1,640,660	57.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,541,500	1,438,550	2,102,950	40.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000	1,159,100	1,840,900	38.64
2105	Нормативт зардал	116,516,600	84,463,494.90	32,053,105.10	72.49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,090,300	68,065,146.90	31,025,153.10	68.69
210502	Хоол, хүнс	16,136,200	15,108,248	1,027,952	93.63
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,290,100	1,290,100	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,691,400	9,360,000	331,400	96.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,333,300	4,096,000	237,300	94.52
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,400,000	4,305,900	94,100	
210604	Урсгал засвар	958,100	958,100	-	100
2107	Томилолт, зочны зардал	3,600,000	1,435,300	2,164,700	39.87
210702	Дотоод албан томилолт	3,600,000	1,435,300	2,164,700	39.87
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,705,000	5,685,000	2,020,000	73.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000	5,280,000	720,000	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	-	200,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	300,000	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000	80,000	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000	25,000	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000		300,000	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000	-	500,000	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300,000		300,000	-

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,000,000	11,054,585	2,945,415	78.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,000,000	11,054,585	2,945,415	78.96
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	509,564,200	516,551,053	(6,986,853)	101.37
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,229,300	31,525,283	5,704,017	84.68
132001	Орон нутгийн төсвөөс	37,229,300	31,525,283	5,704,017	84.68
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	472,334,900	484,655,770	(12,320,870)	102.61
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	472,334,900	484,655,770	(12,320,870)	102.61
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	370,000	(-370,000)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	370,000	(-370,000)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,794,912.23	(1,794,912.23)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,816,710	(8,816,710)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100
620004	Гэрээт ажилтан	1	1	-	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17	17		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,132,196	13,288,930
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,132,196	13,288,930
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,132,196	13,288,930
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,246,440	-
210101	Үндсэн цалин	8,466,690	
210102	Нэмэгдэл	12,779,750	
2104	Хангамж, бараа материалын зардал	3,795,550	-
210402	Тээвэр, шатахуун	3,795,550	
2105	Нормативт зардал	5,090,206	13,288,930
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,090,206	13,288,930
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,000,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,000,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,000,000	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,132,196	13,288,930
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,132,196	13,288,930

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төв нь хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжийг сайжруулах, хүн амыг эрүүлжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн иргэдийнхээ эрүүл мэндийг дээдэлж, аймгийн түвшинд тэргүүлсэн, ёс зүйтэй чадварлаг хамт олонтой, үйлчлүүлэгчдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ гэсэн алсын харааг тодорхойлж, Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах жил болгон зарласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүнд:

- *Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай”*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.6 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.8	8.8	7.0
Авлага	28.0	6.0	(22.0)
Бараа материал	24.0	31.8	7.8
Үндсэн хөрөнгө	370.4	387.2	16.8
Нийт хөрөнгө	424.2	433.8	9.6
Өр төлбөр	18.7	0.1	(18.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	405.5	433.7	28.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	424.2	433.8	9.6

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг болсны дагуу Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаар тоот албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй, өмнөх оноос 7.0 сая төгрөгөөр өссөн байна.
- ✓ Өмнөх онд аймгийн эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 27.0 сая төгрөг байсныг тайлант онд санхүүжилтээр авч барагдуулж оны эцэст 6.0 сая төгрөгийн авлага нь ажиллагсдаас авах авлага 1.6, гэрэл цахилгааны авлага 0.2, түлш халаалтын авлага 1.6, эмийн авлага 2.6 сая төгрөг байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 7.8 сая төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжилт авч байгаатай холбоотой 3 сарын эмийн нөөц бүрдүүлсэн, тайлант хугацаанд Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, аймгийн Онцгой байдлын газраас 2.4 сая төгрөгийн ковидын оношлуур, тестийг үнэ төлбөргүйгээс олгогдож зарцуулаагүйгээс үлдэгдэлтэй, хүнсний материалын үлдэгдэл оны эхнээс 4.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- ✓ Өр төлбөрийн хувьд өмнөх онд үүссэн өглөгийг тайлант онд бүрэн барагдуулан, тайлант онд 0.06 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 34.6 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 443.3 сая төгрөг бүгд 477.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж тайлант оны эхэнд 444.7 сая төгрөгөөр баталж, оны эцэст 509.5 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 484.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 31.5 сая төгрөг, ЭМГ-аас 0.4 сая төгрөг нийт 516.6 сая төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвөөс 5.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу, ЭМДС-аас өмнөх оны 12.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч 509.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая. төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
1	71602/80302- Нэг иргэнд ногдох нормативаар	269.7	264	5.7	97.9
2	71602/81603- Үндсэн мэргэжлийн тусламж	172.9	186.5	(13.6)	107.9
3	71602/83603- Нэмэлт- дээд шатны төсвөөс хуваарилсан	34.6	34.6	-	100.0
4	71602/80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	29.9	29.3		98.0
5	71602/80112- Нийтлэг үйлчилгээ	2.4	2.2		91.7
ДҮН		509.5	516.6	-7.9	101.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөх оны 27.1 сая төгрөгийн авлагыг ЭМДС-аас нэмэлт санхүүжилтийн дансаар авч 13.3 сая төгрөгийг эмийн өглөгийг барагдуулан 13.8 сая төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэн эмчилгээ үйлчилгээний үйл ажиллагааны зардал гаргасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2023 оны 02 дугаар сарын 17-ноос 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 08 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 527.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5.5 сая төгрөгөөр тогтоосон байсныг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар буюу 7.1 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 4.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын ЭМТөв нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд албан томилолт, 10 дугаар зүйлд цалин хөлс, нэмэгдэл, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн зүйл худалдан авах зардалтай холбоотой Төрийн албаны хуулийн 59.1.6 заалт, эмч мэргэжилтэнд хөдөлмөр хамгааллын хувцас бэлтгэсэн, тушаал шийдвэргүй хүнсний материалаас эмч нарын үзлэг, эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад 6.0 сая төгрөгийн бараа материал, хөрөнгө зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу тайлант онд орлогын 21 ажил гүйлгээнээс 12 ажил гүйлгээг мэдээлээгүй, 2 ажил гүйлгээг мэдээллийг хугацаа хоцроож, зарлагын 1 ажил гүйлгээ, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан, өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр оруулаагүй, үр дүнгийн урамшуулалтай холбоотой гарсан шийдвэрийг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 31.3 сая төгрөгийн албан шаардлага, 3.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 43 хувьтай байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.6	1	0.6	100
Албан шаардлага	1	31.3	-	-	
Зөвлөмж	2	3.5	1	1.0	28.6
Нийт дүн	4	35.4	2	1.6	43.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцлон анхаарах асуудал аудит хийх явцад эмч мэргэжилтэнд олгосон цалин, илүү цагийн нэмэгдэл, эм болон шатахууны зарцуулалтыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 41.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа. Үүнд:

- Аймгийн Онцгой байдлын газраас 2022 оны 8 сард нэг бүр нь 12.0 мянган төгрөгийн үнэтэй 200 ширхэг 200 ширхэг буюу 2.4 сая төгрөгийн түргэвчилсэн оношлуур,
- ЭМГ-аас ирүүлсэн эм эмнэлгийн хэрэгслийг 18.2 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг 3.4 сая төгрөгөөр дутуу,
- Мөнгөн гүйлгээний тайланд орон нутгаас олгосон санхүүжилтийг 0.5 сая төгрөгөөр илүү,
- Өглөгийг хасах тэмдэгтэй 1.6 сая төгрөгөөр тусгасан,
- Тайлант үеийн үр дүнг 15.4 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 16.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 16.3 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Батлагдаагүй зардалд 0.2 сая төгрөгийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; ”16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт Байгууллагын данснаас 2022 оны 3 сарын 24-ний өдрийн 2.3 тоот төлбөрийн хүсэлтээр анхан шатны баримт бүрэн бус, байгууллагын тамгагүй, зарлагын ажил гүйлгээг гаргасан Төрийн сангийн мэргэжилтэн хянаж баталгаажуулаагүй нь Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" -ын 7.5-д "Тухайн байгууллага бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтад заасан ТТ-1, ТТ-2 маягтын дагуу 2 хувь үйлдэн харьяалагдах төрийн санд хүргүүлнэ. Төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийн он сар өдөр, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилалд засвар хийсэн тохиолдолд тухайн байгууллагын тамга, санхүүгийн тэмдгийг засвар хийсэн хэсэгт дарж баталгаажуулсан байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны холбогдох заалтыг мөрдөн ажиллах,

5.2.2 Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт Санхүүгийн тайлан дахь хүнсний материалын үлдэгдэл нь эд хариуцагчийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй, эмийн болон шатахууны бараа материалын тайлан гаргалт хангалтгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:" 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Бараа материалын тайланг сар бүр гарган тооцоог бодож хэвших

5.2.3 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт Тушаал шийдвэргүйгээр эмч мэргэжилтэнд түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1.Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Тушаал шийдвэргүйгээр ажил гүйлгээ гаргахгүй байх

5.2.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт:Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг мөрдөөгүй цайллага, Төрийн албаны хуулийн 59.1.6 заалт, эмч мэргэжилтэнд хөдөлмөр хамгааллын хувцас бэлтгэсэн, тушаал шийдвэргүй хүнсний материалаас эмч нарын үзлэг, эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад 4.7 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл

ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

5.2.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .

Илрүүлэлт Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу тайлант онд орлогын 21 ажил гүйлгээнээс 12 ажил гүйлгээг мэдээлээгүй, 2 ажил гүйлгээг мэдээллийг хугацаа хоцроож, зарлагын 1 ажил гүйлгээ, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан, өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр оруулаагүй, үр дүнгийн урамшуулалтай холбоотой гарсан шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д" Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдэгдлийг тогтмол мэдээлнэ" хуулийн заалтыг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийг мөрдөн ажиллаж 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг бүрэн байршуулж хэвших

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө, бараа материалыг орлогод аваагүй санхүүгийн үр дүнгийн тайланд орлого дутуу бүртгэсэн	1	20.6	1	20.6			1	20.6
Тайлант үеийн үр дүн дутуу илэрхийлсэн	1	15.4			1	15.4	1	15.4
Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт илүү бүртгэсэн	1	0.5			1	0.5	1	0.5
Санхүүгийн тайланд өглөгийг хасах тэмдэгтэй илэрхийлсэн	1	1.6			1	1.6	1	1.6
Тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардал дутуу тусгасан	1	3.4	1	3.4			1	3.4
Дүн	5	41.5	3	24.0	3	17.5	5	41.5

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Анхан шатны баримт бүрэн бус, байгууллагын тамгагүй, зарлагын ажил гүйлгээнд Төрийн сангийн мэргэжилтэн хянаж баталгаажуулаагүй	1	4.3					1	4.3
Санхүүгийн тайлан дахь хүнсний материалын үлдэгдэл нь эд хариуцагчийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй, эмийн болон шатахууны бараа материалын тайлан гаргалт хангалтгүй	1	0.7					1	0.7
Батлагдаагүй зардлыг төсвөөс санхүүжүүлсэн	1	0.2	1	0.2				
Тушаал шийдвэргүйгээр түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	5.3					1	5.3
ДҮН	4	10.5	1	0.2	-	-	3	10.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг мөрдөөгүй цайллага, Төрийн албаны хуулийн 59.1.6 заалт, эмч мэргэжилтэнд хөдөлмөр хамгааллын хувцас бэлтгэсэн, тушаал шийдвэргүй хүнсний материалаас эмч нарын үзлэг, эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад материал зарцуулсан	1	6.0	-	-	-	-	1	6.0
Дүн	1	6	-	-	-	-	1	6.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын ажил гүйлгээ, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлээгүй	1	-					1	
Дүн	1	-	-	-	-	-	1	
Нийт дүн	2	6.0	-	-	-	-	2	6.0

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 15/A2160424

Ховд

ХОА-2022/175/НА/СТА-ТШЗ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар эмч нарын зөвлөгөөний хураамж гэсэн утгаар төсвөөс сургуулийн ойн хандивт 200.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Дээрх зөрчилтэй холбоотой 200000 /хоёр зуун мянган төгрөг/-ийг их эмч Дагиймаагаар төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 05-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн дарга Н.Мөнхзул, нягтлан бодогч Г.Сэрээтэр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Д.НАРАНТУУЛ